



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/98

Мандалговь

О.Бархүүг үнэлгээний хорооны даргаар
нөхөн томилох тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1, 47.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Сайнцагаан сумын Далай хорооллын 0.4кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын ажил”-ын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны дарга Г.Жавзмаа /Аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн мэргэжилтэн/ нь өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлт гаргасан тул үнэлгээний хорооны даргаас чөлөөлсүгэй.

2. Тус ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны даргаар Дундговь-Ус ОНӨҮГ-ын дарга /О.Бархүү/-г нөхөн томилсугай.

3.Тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу шуурхай зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга /О.Бархүү/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *Ч. ДОРЖБАТ* Л.ДОРЖБАТ



486210421

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Л.ДОРЖБАТ ТАНАА ХҮСЭЛТ ГАРГАХ НЬ:

Миний бие Ганхуягийн Жавзмаа АЗДТГ-ын ТЗУХ-ийн Дотоод ажил, өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтнээр 5 дахь жилдээ ажиллаж байна. 2011 онд МУИС-ийг Эдийн Засгийн сургуулийг "Менежмент, Олон улсын худалдааны эдийн засагч" мэргэжлээр сурч төгссөн.

Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/57 дугаар тушаалаар "Сайнцагаан сумын Далай хорооллын 0,4кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын ажил"-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны даргаар томилогдсон байна. Миний хувьд цахилгаан, эрчим хүчний чиглэлийн мэргэжлийн хүн биш учраас аймаг орон нутагт хийгдэх бүтээн байгуулалтын ажлыг чанартай, мэргэжлийн өндөр түвшинд хийгдээсэй гэж хүсэж байна.

Иймд "Сайнцагаан сумын Далай хорооллын 0,4кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын ажил"-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооноос чөлөөлж өгөхийг хүсэж байна.

Вяан зүгийн амтгай

ХҮСЭЛТ ГАРГАСАН,

ч. Доржбат - Г. Жавзмаа

Г.ЖАВЗМАА

Чингэлтэй хорооны даргаар

(9093-9008, 3Ф89060305)

Ус зүгийн "Дундговь-Ус" БНХТ-г

дүрэг О. Бэрхүү - 2 канон тэмдэг

Л. Доржбат *Г/А*